15

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн

# ТОГТООЛ

1963 оны I дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 8 | Улаанбаатар хот

Хэмжүүр шалгах,засварлах тасаг
орон нутагт байгуулах тухай.

Орон нутгийн хэмжүүр шалгах,засах ажлыг байнга болгож хэмжүүрийн ашиглалтад тавих хяналт шалгалтыг сайжруулах зорилгоор БНМА Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

I.Орон нутгийн хэмжүүрийг төвөөс шалган засварлаж байгаа одоогийн журмыг өөрчилж,хэд хэдэн аймгуудын хэмжүүрийг шалгаж,засварлах үүрэгтэй аймаг дундын тасгуудыг 1963 оноос эхлэн аж ахуйн тооцооны үндсэн дээр дор дурдсан аймгуудад байгуулсугай:

а/Баянхонгор,Өвөрхангай,Өмнөговь,Дундговь аймгуудын хэмжүүрийн шалгалт,засварын тасгийг Өвөрхангай аймагт;

б/Баян-өлгий,Увс,Ховд,Говь-алтай аймгуудын хэмжүүрийн шалгалт,засварын тасгийг Ховд аймагт;

в/Хөвсгөл,Булган,Архангай,Завхан аймгуудын хэмжүүрийн шалгалт,засварын тасгийг Булган аймагт;

г/Хэнтий,Дорнод,Сүхбаатар,Дорноговь аймгуудын хэмжүүрийн шалгалт,засварын тасгийг Хэнтий аймагт;

д/Төв,Сэлэнгэ аймаг,Улаанбаатар хотын хэмжүүрийн шалгалт,засварын тасгийг Улаанбаатар хотод тус тус төвлөрүүлсүгэй.

2.Аймаг дундын хэмжүүрийн шалгалт,засварын тасгуудын төлөвлөгөөний биелэлтэд нь хяналт тавьж,өдөр дутмын удирдлагаар хангах,төвөөс батлагдсан хуваарьш дагуу аймгуудад ажиллуулах,аж ахуй санхүүгийн талаар үйлчлэх зэрэг асуудлыг Өвөрхангай,Ховд,Булган,Хэнтий аймгийн ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаадын ерөнхий хэлтэст хариуцуулсугай.

3.Хэмжүүрийн шалгалт,засварын тасаг бүрд ажиллах улсын шалгагч,слесарьч,жолооч нарын тогтмол цалинг одоо байгаа хэмжээгээр нь тогтоосугай.

4.Хэмжүүрийн шалгалт,засварын тасгуудын төсөв төлөвлөгөө батлах,үлгэр жишээ хэмжүүрүүд,ажиллах мэргэжлийн хүмүүсээр хангаж байхаас гадна,тэдгээр тасаг бүрд ГАЗ-69 машин нэгийг шилжүүлэн өгөхийг Улсын Стандарт,Хэмжүүрийн Хэрэг Эрхлэх Газар /н.РАВДАНСАМБУУ/-д даалгасугай.

5.Шалгах хэмжүүрийн тоо нэмэгдсэнийг харгалзан, Улсын Стандарт,Хэмжүүрийн Хэрэг Эрхлэх Газарт 1963 оноос эхлэн хэмжүүрийн шалгалт,засварын бригад нэгийг нэмэгдүүлэн,орон тоо,цалингийн хэмжээг нь баталж өгөхийг Хөдөлмөр,цалин хөлсний улсын хороо /н.ШАРАВ/-д даалгасугай.

БНМА Улсын Сайд нарын Зөвлөлийн I-р орлогч дарга МОЛОМЖАМЦ

БНМА Улсын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга БАДАРЧ

Хуулбар үнэн:Тогтоол ангийн эрхлэгч [signature] /ДАГВАДОРЖ/

Б.Н.М.А. ... ТОГТООЛ АНГИ ... ЗӨВЛӨЛИЙН ...